

Гуйлгачин Лазар

-The Beggar Lazarus-



75Page



76Page



77Page



78Page



79Page

Эрт цагт маш баян хүн амьдардаг байлаа. Тэр гоё тансаг гэрт элдэв үнэтэй хувцас өмсөн амьдарч байв. Тэгээд өдөр бүр дээд зэргийн найрыг хийж найзуудаа дуудан хөгжилддөг байлаа. Түүнд ингэж амьдрах нь сайхан байлаа. Баян эр Бурханд итгэдэггүй зөвхөн өөрийнхөө төлөө амьдардаг байв.

Баяны гэрийн үүдэнд Лазар хэмээх юу ч үгүй гуйлгачин амьдарч байлаа. Тэр баяны хашааны үүдэнд хэвтэж биен дээр нь гарсан яр шархнаас болж зовдог байлаа. Тэр сольж өмсөх хувцасгүй учир бохир заваан дээрээс нь баяны ширээнээс унах хоолны үлдэгдэл байна уу үгүй юу гэж гэж ажиглан харж түүж иддэг байв. Гуйлгачин Лазарыг хэн ч тоодоггүй байлаа. Харин нэгэн өдөр тэр Бурханд итгэж, итгэлийн хүн болдог.

Гуйлгачин Лазар нас барав. Лазарыг Бурханы илгээсэн зарц нар дагуулан тэнгэрийн улсад аваачив. Тэр газарт Лазар Бурханд хамгийн сайн итгэдэг байсан өвөг дээдэс Абрахамтай хамт байлаа.

Төд удалгүй баян хүн ч үхэв. Баян хүн тамд унан, маш аймшигтай зовлон эдлэв. Тамын гал хэзээ ч унтардаггүй бас маш халуун. Баян маш хэцүүгээр зовж шаналан ам нь цангаж ус хайв. Харин тэр газарт уух ус байсангүй.

Зовон шаналж байсан баян санаандгүй дээшээ хартал тэнгэрийн улс харагдав. “Хөөх юу болох нь энэ вэ? Гуйлгачин Лазар бидний өвөг дээдэс Абрахамын өвөрт тэврүүлсэн байх чинь”, тэгээд баян, гуйлгачин Лазарт маш ихээр атаархав. Тэгээд өвөг дээдэс болох Абрахам руу хашгирч гарав. “Абрахамаа, амь авраач би гал дунд тарчлан зовж байна. Маш халуун байна. Та ядаж Лазараар ч болов дамжуулаад дусал ус явуулж хэлийг минь дэвтээгээч” хэмээн хашгирав.

Абрахам түүнд хандан, “Баян хүн гуай, Лазар чам руу явж чадахгүй. Чи дэлхий дээр амьдарч байхдаа сайн зүйлийг л харж өөрийнхөө төлөө л аз жаргалтай амьдарсан. Чи одоо үүнийхээ төлөө тамын шийтгэлийг авч байна. Тэгээд ч чи бидний хооронд маш том ангал байгаа учир бид тийшээ очиж чадахгүй. Мөн тэр газраас нааш нь ирж ч чадахгүй”



80Page

.....
Баян ихээр гуниглан уйлав. Тэгээд сэтгэлээсээ Абрахамаас гуйв. “Тэгвэл Лазарыг дахин амилуулан манай гэр рүү явуулж өгөөч. Тэгээд ах дүүсд маань тэнгэр улс болон тамын тухай хэлж өгч, тэд энэ газарт ирэхгүй байхаар хийж өгөөч”

Абрахам түүнд хандаж “ Тэдэнд тэднийг удирдах Мосе болон эш үзүүлэгчид байгаа. Бурханы үгийг сонсож буруу зүйлсээ засаж залруулахгүй бол үхсэн хүн дахин амилаад очсон ч тэд сонсохгүй”, “үхсэн хүн амилаад очвол үнэхээр итгэж гэрийнхэн маань Есүст итгэн аврагдах боломжтой болно шүү дээ.

Туслаач, гуйж байна”. Баян чин сэтгэлээсээ гуйж байв.

Абрахам түүнд дахин “ Тэр тийм бишээ, хүмүүс дамжуулсан үгийг сонсох ч үгүй итгэх ч үгүй байгаа хүмүүс үхсэн хүн дахин амилаад буцаж очин тамын аймшигтай газар болохыг хичнээн ярьсан ч хэзээ ч буруугаасаа эргэхгүй.

Есүст ч итгэж чадахгүй. Тиймээс хэн ч байсан амьд байхдаа Бурханы үгийг сонсож буруугаасаа эргэх хэрэгтэй”

Баян амьд байхдаа гуйлгачин Лазарт нэг ч удаа тусалж байгаагүй. Хөршөө хайрлахыг мэддэггүй хүн байв.

.....
Энэ баян хүн шиг Бурханыг хайрлаж мэддэггүй хүн Бурханы ард түмэн болж чадахгүй. Бурханыг хайрлаж, хөршөө өөрийн бие мэт хайрла гэж Есүс бидэнд хэлсэн байдаг.



81Page